



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/91

Төмөрбулаг сум

Газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төмөрбулаг сумын Засаг даргын санал, иргэн Д.Болдбаатарын ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн А/63 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 2 дахь заалтаар иргэн Их мэргэд овгийн Доржийн Болдбаатар (РЛ68051611)-д "Гэр, орон сууц хашааны газрын зориулалттай"-гаар эзэмшүүлсэн Төмөрбулаг сумын 5 дугаар Жаргалант 6-1А тоотод байршилтай 6716000966 нэгж талбарын дугаартай 124м<sup>2</sup> газрын зориулалтыг өөрчилж, "Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор ." газрын зориулалттай болгон үлдсэн 39 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч иргэн Доржийн Болдбаатар (РЛ68051611)-тэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн (Б.Батмөрөн), Улсын бүртгэлийн ажилтан (Д.Пүрэвдорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн (Б.Батмөрөн)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Нямханд)-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.МӨНХ-ЭРДЭНЭ